



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 691

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дархан нэхий” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,105,479 /нэг сая нэг зуун таван мянга дөрвөн зуун далан ес/ ширхэг энгийн хувьцааг 1000 хувааж нэг бүр нь 10 /арав/ мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 1,105,479,000 /нэг тэрбум нэг зуун таван сая дөрвөн зуун далан есөн мянга/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Дархан нэхий” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт, тавьж олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН